

Төслийн товчоон

ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

2017 оны 4-р сар

Хэрэгжүүлэгч:



Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

БАРИМТ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл

Хугацаа:

2016 – 2018

Төсөв:

2.4 сая шв.франк

Зорилтот бүлэг:

Хөдөө орон нутаг болон хот суурин газрын захад амьдарч буй хөдөлмөр эрхлээгүй залуучууд

Зорилтот бүс нутаг:

- Улаанбаатар хот:
- Баянгол дүүрэг
 - Хан-Уул дүүрэг

Найман аймаг:

- Увс
- Завхан
- Баян-Өлгий
- Ховд
- Говь-Алтай
- Баянхонгор
- Дархан-Уул
- Өмнөговь



© ШХА

Ховд аймгийн Политехникийн коллежийн жимс жимсгэнэ, хүнсний ногоо үйлдвэрлэлийн ангийнхан дадлага хийж буй нь

ОРШИЛ

Тогтвортой, өрсөлдөөнт эдийн засгийг бүрдүүлэх суурь, арга хэрэгсэл нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих явдал гэдгийг Монгол Улсын Засгийн газар онцлон тэмдэглэж, залуучуудыг ажлын байраар хангахад чиглэсэн арга хэмжээг илүү хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Улмаар,

Монгол Улсын Засгийн газраас гаргасан хүсэлтийн дагуу, Швейцарийн хөгжлийн агентлаг залуучуудын ажилгүйдлийн асуудлыг тогтолцооны түвшинд шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхийг зорин ажиллаж байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛТ:

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар Монгол Улсын нийгэм-эдийн засгийн эрх тэгш, тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах

Энэхүү зорилтоо дараах гурван үр дүнд хүрэх замаар биелүүлнэ. Үүнд:

1. Үндэсний бодлого, хөтөлбөрүүд нь залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэнэ.
2. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн үр дүнтэй үйлчилгээ үзүүлнэ.
3. Залуучууд өсөн дэвжих ирээдүйтэй гарааны бизнес эрхлэнэ.

ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:



1. **Макро-түвшинд:**
Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого боловсруулах, сайжруулахад дэмжлэг үзүүлэх



2. **Дунд-түвшинд:**
Орон нутгийн түвшинд залуучуудад хүргэх хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх



3. **Микро-түвшинд:**
Залуучуудаар удирдуулсан шинэлэг санаачилга бүхий гарааны бизнесийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

ШХА-ийн зорилго:

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн эрх тэгш, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахыг зорино.

 <p>Үндэсний бодлого, хөтөлбөр нь залуучуудын хөдөлмөр эрхлэлтэд таатай орчин нөхцөл бүрдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> • Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг боловсруулах • Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг оновчтой болгох • Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх удирдах механизмыг бий болгох 	 <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн үр дүнтэй үйлчилгээг үзүүлэх</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний арга зам, үйл явцыг оновчтой болгох, сайжруулан турших • Төсөл хэрэгжиж буй аймаг, дүүргийн ХХҮГ-ын мэргэжилтнүүдийн чадавхийг дээшлүүлэх • Орон нутгийн хамтын ажиллагаа, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх 	 <p>Залуучууд цаашид өргөжин тэлэх боломжтой гарааны бизнес эрхлэх</p> <ul style="list-style-type: none"> • Бизнесийн гараагаа эхлүүлж буй залуучуудын гарааны бизнест дэмжлэг үзүүлэх загвар схемийг боловсруулан турших • Бизнес хөгжлийн байгууллагуудыг чадавхжуулах • Гарааны бизнес эрхлэхэд чиглэсэн зөвлөгөө мэдээлэл өгөх
--	---	---

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХҮРСЭН ГОЛ ҮР ДҮН

ХНХЯ-нд бодлогын дэмжлэг үзүүлэх:

- Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Үндэсний хөтөлбөр боловсруулахад ХНХЯ-д туслалцаа үзүүлсэн.
- Төслөөс боловсруулсан “Залуучуудын гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн анхны хувилбарыг ХНХЯ эцэслэн боловсруулж, улмаар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл баталсан.

Залуучуудад хүргэх хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг сайжруулах:

- Сонгосон аймаг, дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт туршин хэрэгжүүлэх Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жишиг үйлчилгээ нэвтрүүлэх Хөдөлмөрийн загвар хэлтсийн үйл ажиллагааны аргачлал, үйл явц, арга хэрэгслийг боловруулсан.
- Үндэсний стандартын хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа явуулах, хөдөлмөр эрхлэлтийн үр дүнтэй үйлчилгээ үзүүлэх чиглэлээр орон нутгийн хөдөлмөрийн албадын ажилтнуудын чадавхыг дээшлүүлсэн.

Хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих, бэхжүүлэх:

- Аймаг, дүүргийн иргэдийн хурал болоод орон нутгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлөөс төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжиж ажиллав.
- Ажил олгогч эздийн байгууллага (МАОЭНХ) нь хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг зорилтот аймгуудийн Засаг даргын тамгын газар болон Үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаатай уялдуулав.

Залуучуудын гарааны бизнесийг дэмжих:

- Улсын хэмжээнд гарааны бизнесийн үйл ажиллагаа эрч хүчээ авч, залуучуудын хамрах хүрээ улам бүр нэмэгдсэн.
- Гарааны бизнес болон түүнтэй холбогдох нэр томъёоны тайлбар толь, чухал хэрэгцээтэй гарын авлагуудыг боловсруулсан.
- Шинэлэг санаачилга бүхий залуучуудын гарааны бизнесүүдэд зориулсан бизнесийн сургалт, санхүүжилтийн шинэ боломжуудыг олгож байна.

Хамтран хэрэгжүүлэгч түншүүд:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)
- Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар
- Орон нутгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газар, хэлтсүүд
- Монголын ажил олгогч эздийн холбоо
- Залуучуудын ТББ-ууд
- Гарааны бизнес эрхлэгчид
- Бизнес хөгжлийн үйлчилгээний байгууллагууд

Холбоо барих:

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл

Монгол Улс, Улаанбаатар хот СБД дүүрэг, Залуучуудын өргөн чөлөө, Блю Мон төв # 602

- +976-77116171
- +976-7711 6171
- info@yep-gfa.mn

Швейцарийн ЭСЯ-ны Хамтын ажиллагааны газар

Монгол Улс, Улаанбаатар хот Элчингийн гудамж, 1-р хороо Скай Плаза Бизнес төв Ш/Х 37, Улаанбаатар 14210

- +976 11 331422
- +976 11 331420
- ulaanbaatar@eda.admin.ch
- www.swiss-cooperation.admin.ch/mongolia
- Swiss Cooperation in Mongolia



Н.Наранбаатар, орон нутаг дахь гарааны бизнес эрхлэгч өөрийн бизнес санааг Дархан-Уул аймагт зохион байгуулсан "Гарааны бизнес" арга хэмжээнд танилцуулж байгаа нь, 2017 оны 2 сарын 10